



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 435

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, 10 нэрийн нийт 13,380,600.00 (арван гурван сая гурван зуун наян мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2."Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ичинхорлоо, "Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Цагаанхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 435 дугаар тогтоолын хавсралт

"ДБҮЭГ" ТӨҮГ-ын балансаас "Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-ын балансад шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Марк	Тоо шир хэг	Нэгжийн үнэ (төгрөгөөр)	Хөрөнгийн үнэ (төгрөгөөр)
1	2 чихний хүлээн авагчийн чихэвч	Headphone	20	50,160.00	1,003,200.0
2	Микрофоны хөл	HCS-5300TZJ2	4	104,300.00	417,200.0
3	Чанга яригч	linear array speaker	4	601,750.00	2,407,000.0
4	Чанга яригч	monitor and apron stage speakers	2	1,083,000.00	2,166,000.0
5	Чанга яригчийн тогтоогч	Speakers support	6	120,000.00	720,000.0
6	Өсгөгч	Linear array amplifier	2	722,100.00	1,444,200.0
7	Хөнгөн цагаан тайз	M2	12	212,500.00	2,550,000.0
8	Тайзны чанга яригч	monitor and apron stage speakers	4	230000	920,000.0
9	Микрофон wireless	Wireless handheld microphone	1	1493000	1,493,000.0
10	Зурагт	19" LCD	2	130,000.00	260,000.0
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		57 (тавин долоо)		13,380,600.00 (арван гурван сая гурван зуун наян мянга зургаан зуун)